



**ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 25 өдөр

Дугаар А/1234

Хэрлэн сум

**Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх  
хаврын дархлаажуулалтын ажлыг зохион  
байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4, 6.6, 9 дүгээр зүйлийн 9.1-9.9, 28 дугаар зүйлийн 28.4 дэх хэсэг, Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын 2025 оны 04 дүгээр сарын 18-ны өдрийн А/125 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтыг аймгийн бүх үхэр, гахайг хамруулан 2025 оны 04 дүгээр сарын 20-ны өдрөөс эхлэн 28 хоногийн хугацаанд зохион байгуулсугай.

2. Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн хүрээнд технологит хугацаанд нь гүйцэтгүүлэх, уг ажлын явц, чанарт хяналт тавьж ажиллах аймгийн Онцгой комиссын гишүүдийн хуваарийг хавсралтаар баталсугай.

3. Малчдад урьдчилан мэдэгдэж тарилгын хашаа, хоолойг бэлтгүүлэх, дархлаажуулалтад ажиллах хүн хүч, машин техник, шатах тослох материалын бэлэн байдлыг хангуулан, багийн Засаг дарга нарыг үүрэгжүүлж ажиллахыг сумын Засаг дарга, урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад шаардагдах вакцин, мэргэжлийн удирдлага, заавар зөвлөмжөөр хангах, дархлаажуулалтын явц, технологи, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн газрын дарга (Н.Анхбаяр)-д, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Өнөрцолмон)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

ДАЮУРБУНЬ





سپهر سنجش و سنجش  
سپهر سنجش و سنجش

سپهر سنجش و سنجش

سپهر سنجش و سنجش


سپهر سنجش و سنجش

سپهر سنجش و سنجش


سپهر سنجش و سنجش

سپهر سنجش و سنجش

سپهر سنجش و سنجش



سپهر سنجش و سنجش



Гишүүдийн хуваарь

Д/Д	Сумдын нэр	Онцгой комиссын гишүүдийн нэрс	Албан тушаал
1	Галшар	Б.Амгаланбат	Байгаль орчны газрын дарга
2	Баянхутаг	Б.Өнөрцолмон	Аймгийн Засаг даргын орлогч
3	Баянмөнх	О.Баярлхагва	Тагнуулын хэлтсийн дарга
4	Дархан	Б.Золбоо	Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
5	Дэлгэрхаан	А.Жаргалсайхан	Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга
6	Жаргалтхаан	Ж.Эрдэнэбат	Онцгой байдлын газрын дарга
7	Цэнхэрмандал	Ү.Энх-Ариунаа	Улаан загалмайн хорооны дарга
8	Өмнөдэлгэр	Ч.Баярцолмон	Хууль, эрх зүйн хэлтсийн дарга
9	Батширээт	Л.Цэнддорж	Цэргийн штабын дарга
10	Биндэр	Л.Дашнамжилмаа (үүрэг гүйцэтгэгч)	Эрүүл мэндийн газрын дарга
11	Баян-Адарга	Н.Анхбаяр	Мал эмнэлгийн газрын дарга
12	Дадал	Б.Түмэнжаргал	Нийгмийн бодлогын хэлтсийн дарга
13	Норовлин	Б.Бат-Эрдэнэ	Онцгой байдлын газрын орлогч, урьдчилан сэргийлэх тасгийн дарга
14	Батноров	Д.Баярхүү	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга
15	Баян-Овоо	Х.Уртнасан	Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын дарга
16	Мөрөн	Н.Үнэнбат	Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга
17	Хэрлэн	Д.Эрдэнэбаатар	Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чингис хотын Захирагч
18	Бор-Өндөр	Э.Жавхлантөгс	Цагдаагийн газрын дарга